

Нийтлэл #2



Өрсөлдөөний эрх зүйн маргаан: Улсын дээд шүүхээс босоо хэлбэрийн картелийг тодорхойлсон нь

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com


Энхжаргалын Аззаяа

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
azzaya.enkhjargal@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд Аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлах зорилготой гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглоно гэж заасан байдаг. Өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл буюу картелийн 4 төрөл байхаар зохицуулсан бөгөөд тэдгээрийн нэг нь бараа, бүтээгдэхүүний үнийг харилцан тохиролцоох хэлцэл юм.

Өрсөлдөөний тухай хуульд тодорхойлсноор картел нь аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан байх ба ингэхдээ хэвтээ болон босоо хэлбэрийг нарийвчлан заагаагүй ч 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн Улсын Дээд шүүхийн тогтоолоор ямар тохиолдолд босоо хэлбэрийн картель байх талаар дүгнэлт хийсэн байна.

Иймд Монгол Улсын Дээд шүүхээс өрсөлдөөний эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ картелийг хэрхэн тайлбарласан талаар хураангуйлан энэхүү нийтлэлээр толилуулав.



Юу болов?

М ХХК нь үйлдвэрлэгч компани бөгөөд тус компани нь дэлгүүр, супермаркетуудтай байгуулсан нийлүүлэлтийн гэрээндээ бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчид борлуулах үнийг тогтоож өгсөн нь өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэлд тооцогдож, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын (“ШӨХТГ”) улсын байцаагчид бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоосон зөрчил гаргасан гэж үзэж тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 6 хүртэл хувиар торгох зохицуулалтыг үндэслэн 1,209,682,136 төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулжээ.

М ХХК нь тус шийтгэлийг эс зөвшөөрч, зөрчилд шийтгэл ногдуулах тухай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан байна.



Шүүхийн шийдвэр

Маргааныг 3 шатны шүүх хянан шийдвэрлэсэн ба анхан шатны шүүх М ХХК-ийн гомдлыг хангаж шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүх болон улсын дээд шүүхээс М ХХК-ийг картель байгуулсан буюу Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн хэмээн дүгнэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр

М ХХК нь дэлгүүр, супермаркетуудтай байгуулсан гэрээгээр бүтээгдэхүүнийг борлуулах, худалдан авагч тал нь борлуулалтын үнийн дүнгийн тодорхой хувийг авах нөхцөлийг урьдчилан тохиролцож, үнийг тодорхойлсон, хямд үнээр бараа нийлүүлэх баталгааг гаргасан нь бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох гэж заасныг зөрчсөн үйлдэл гэж үзэхээргүй байна хэмээн шүүх дүгнэсэн.

Давж заалдах шатны шүүхийн магадлал

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн ба ингэхдээ дор дурдсаныг үндэслэсэн байна. Үүнд:

- М ХХК нь үйлдвэрлэгчийн хувьд дээрх дэлгүүрүүдэд нийлүүлэх бараа, бүтээгдэхүүний бөөний үнийг тогтоох эрхтэй, гагцхүү тэдгээрийг худалдах буюу борлуулах жижиглэнгийн үнийг гэрээгээр тогтоосон нь борлуулалтын өрсөлдөөнийг хязгаарлах үр дагаврыг бий болгосон.
- Жижиглэнгийн үнийг гэрээгээр тогтоосон нь борлуулагч нарт ижил боломж, ижил нөхцөл мэт харагдах боловч хууль зүйн агуулгаараа тэдгээрийн зах зээлд өрсөлдөх боломжийг үйлдвэрлэгчийн зүгээс хязгаарласан шинжийг өөртөө агуулдаг.
- Өрсөлдөөний эрх зүйд үйлдвэрлэгч борлуулагчдын хооронд байгуулсан картелийг босоо хэлбэрийн картель гэх бөгөөд үүний түгээмэл хэлбэр нь үнэ тогтоох гэрээ байдаг. Тухайлбал үүнд үйлдвэрлэгчээс өөрийн бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтоох буюу үнийн дээд доод хэмжээг тогтоохыг борлуулагчаас шаардах хамаарна.

Хяналтын журмаар гаргасан гомдол

М ХХК нь дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргасан байна. Үүнд:

- Өрсөлдөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд өрсөлдөөний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Эдгээр хуульд шүүхийн магадлалд дурдсан босоо хэлбэрийн картель, үүнд үйлдвэрлэгчээс өөрийн бараа, бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийн тогтоох харилцаа хамаарна гэж заагаагүй. Мөн үйлдвэрлэгч бөөний үнийг тогтоож болно, жижиглэнгийн үнийг тогтоохыг хориглох тухай хуулийн зохицуулалт байхгүй.
- Гэрээнд борлуулах үнийг тодорхойлсон нь зах зээл дээр өрсөлдөгч байгууллагуудын хооронд өрсөлдөөнийг хязгаарласан үйлдэл гаргаж буй хэлбэр огт биш, харин ч нэг өртгөөр гарч буй бүтээгдэхүүнийг ижил төрлийн өрсөлдөгч аж ахуйн нэгжүүдэд ялгаваргүй үнээр хүргэж буй, нөгөө талаас хэрэглэгчдэд хямд үнэ хүргэх зорилготой шударга ажиллагаа юм.



Хяналтын шатны шүүхийн тогтоол

Улсын дээд шүүхээс М ХХК-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хэлэлцээд, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Шүүхийн дүгнэлт:

Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглоно: тус зүйлийн 11.1.1-д бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох гэж заажээ.

Хэдийгээр хууль тогтоогч картелийн хэлбэрийг нарийвчлан заагаагүй ч хууль зүйн онол болон олон улсын практикт ийм төрлийн картелийг босоо ба хэвтээ гэж ангилан авч үздэг. Энэ тохиолдолд нэг талаас М ХХК (үйлдвэрлэгч, нийлүүлэгч), нөгөө талаас жижиглэн борлуулагч аж ахуйн нэгжүүд хоорондоо гэрээ байгуулж, жижиглэнгийн (эцсийн хэрэглэгчид нийлүүлэх) үнийг тогтоож, борлуулагч нар нь хоорондоо үнийн өрсөлдөөн хийх шаардлагагүй болсон нь өрсөлдөөнийг хязгаарласан дахин борлуулалтын үнийг баталгаажуулсан гэрээ (картель) мөн, энэ талаар хуулийн агуулгыг тодотгож тайлбарласан давж заалдах шатны шүүхийн дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй.

Мөн гомдол гаргагч нь тухайн гэрээ байгуулсан зорилгоо тайлбарлахдаа хэрэглэгчид хямд үнийн баталгаа гаргах гэж байгаа боловч хууль тогтоогч хэлцэн тохирч үнэ тогтоох бүхий л хэлбэрийг шударга бус хэмээн хориглосон буюу хэрэглэгчид хүрэх хямд үнэ нь хэлцэл (картель)-ийн журмаар бус, харин өрсөлдөөний үр дүнд хэрэглэгчид бараа бүтээгдэхүүний хямд үнэ тогтох чөлөөт зах зээлийн үзэл баримтлалыг хуульчилсан учир энэ талаарх гомдлыг хүлээн авах боломжгүй байна.

Ийнхүү гомдол гаргагч болон жижиглэн борлуулагчийн хооронд босоо төрлийн картель хийгдсэн үйл баримт тодорхой, Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасан “бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох”-ыг хориглосон заалт зөрчигдсөн байна.



Анхаарах асуудал

Энэхүү маргаанд үйлдвэрлэгч компани нь жижиглэн борлуулагчидтай гэрээ байгуулж, жижиглэнгийн буюу эцсийн хэрэглэгчид нийлүүлэх үнийг тогтоосон байна. Дээрх маргаанаар дурдсан хэлцэлийг шүүх шийдвэрлэхдээ босоо хэлбэрийн картель гэж дүгнэсэн байна. Улмаар Улсын Дээд Шүүхээс үйлдвэрлэгч тал борлуулагчдын хоорондын нийлүүлэлтийн гэрээг хуулиар шууд хориглосон өрсөлдөөний зөрчил гэж үзсэн болох нь харагдаж байна.

Иймд картелийн эсрэг зохицуулалтыг өргөн хүрээнд ойлгож, зөвхөн өрсөлдөгч аж ахуй эрхлэгчид хоорондын гэрээ, хэлцэлээр хязгаарлахгүйгээр нийлүүлэлтийн сүлжээнд хамаарах бүх аж ахуй эрхлэгчид хамааруулж ойлгох, мөн үнэ хэлцэн тогтоох гэсэн босоо хэлбэрийн картелийн түгээмэл зөрчлийг тодорхойлоход хамааралтай өрсөлдөөний хуулийн үндсэн зарчим, жишгийг онцгой анхаарч байх нь чухал байна.



Бидэнтэй холбогдоорой

Өрсөлдөөний хууль тогтоомжийг дагаж мөрдөх болон өрсөлдөөнийг хязгаарласан, өрсөлдөөнд харш үйл ажиллагааны талаар зөвлөгөө авч, ярилцах хүсэлтэй бол бидэнтэй холбогдоно уу. Та шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь уншихыг хүсвэл [энд](#) дарна уу.